



ХҮДРИЙН ХАЯГДЛЫН ДАЛАНГИЙН ШҮҮРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 11 дүгээр сар

“Оюу толгой” уурхайн талбар дахь Хаягдлын далангийн 1-р үүрээс ус шүүрч, Шүүрэл цуглуулах сангаас уурхайн талбайн гадна 60 метрийн зайд шүүрэл тархсаныг тогтмол хийгддэг хяналт шалгалтаар 2021 онд тогтоосон. “Оюу толгой” компанийн бодлого, журмын дагуу дотоод болон хөндлөнгийн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор нарийвчилсан хяналт шинжилгээ хийж, уг шүүрлийг бүртгэсэн.

Үүний дагуу хаягдлын далангийн 1-р үүрээс гарсан шүүрлийг “Засаж залруулах арга хэмжээний иж бүрэн төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөнд гидрогеологийн нарийвчилсан судалгаа, шүүрэл цуглуулах сангийн инженерийн сайжруулалт, зураг төсөл боловсруулах, түүний хэрэгжилтийг долоо хоног тутам ажлын хэсгээр нягтлах зэрэг ажил багтсан. “Оюу толгой” компанийн зүгээс дээрх төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх Ажлын хэсэг байгуулснаас гадна уг төлөвлөгөөний хэрэгжилтэд Зээлдүүлэгчид хөндлөнгийн хяналт тавьж байна. Шүүрэл үүссэний малчдын худгийн усны чанар болон бусад усны нөөцөд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болох нь хяналт шинжилгээний үр дүнгээр батлагдсан.

Засаж залруулах арга хэмжээний үр дүнд хяналт шинжилгээний цооногуудын усны эрдэсжилт (TDS) аажмаар буурч байна. Хаягдлын далангийн 1-р үүр үүр болон шинээр байгуулсан 2-р үүр нь анхны загвар, зураг төслийнхөө дагуу ажиллаж байгаа бөгөөд ямар нэгэн доголдол гараагүй.

Хаягдлын далангаас шүүрэл гарах нь аль ч далангийн дизайны салшгүй хэсэг байдаг бөгөөд хэвийн үзэгдэл юм. Шүүрлийг зориулалтын санд цуглуулан, буцаан үйлдвэрлэлд ашиглах дизайнтай. Хүдрийн хаягдлын далангийн зураг төсөл боловсруулах, ашиглалтад оруулах цагаас эхлэн шүүрлийг цуглуулах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж ирсэн. Шүүрэл гарах, түүнд хяналт шинжилгээ хийх талаар Оюу толгой уурхайн ТЭЗҮ-д нарийвчлан тусгасан байдаг. Шүүрэл цуглуулах систем (суваг шуудуу, сан) нь Хүдрийн хаягдлын даланг аюулгүй ашиглахад тусгайлан зориулж зохион бүтээгдсэн бөгөөд хэвийн үйл ажиллагааны явцад хаягдлын санд үүсэх усны түвшин, даралтыг зохицуулах үүрэгтэй.

Зээлдүүлэгчдийн томилсон Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын тайланд 2022 оноос хойш шүүрлийн асуудлыг тусгаж ирсэн бөгөөд уг тайланг ot.mn холбоосоор үзэх боломжтой.

“Оюу толгой” компани 2019 оноос хойш холбогдох оролцогч талууд, тэр дундаа орон нутгийн төлөөлөгчид, Засгийн газрын байгууллагууд, Зээлдүүлэгчдийн хөндлөнгийн аудитуудтай ил тод, нээлттэй байдлаар харилцаж, зөвлөлдөж ирсэн төдийгүй ажлын талбайд зочлуулж, шүүрлийн нөхцөл байдалтай биечлэн танилцуулж байна.

Орон нутгийн иргэдэд мэдээлэл хуваалцсан, хамтран ажилласан ирсэн тухай товч дурдвал:

- 2022 оны 8-р сар, 2023 оны 9, 11-р сар, 2023 оны 7-р сард Гурван талт зөвлөл (ГТЗ) хуралдаж, ажлын талбайд хүлээн авсан.
- 2022 оны 5-р сард Ханбогд сумын Засаг дарга, орон нутгийн байгаль орчны байцаагчтай уулзсан.
- 2022 оны 6-р сар, 2023 оны 8-р сард орон нутгийн иргэд ажлын талбайд зочилж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.

- 2022 оны 11-р сард хаягдлын далангийн урсгалын доод хэсэгт амьдардаг малчидтай уулзсан.
- 2022 оны 12-р сард Ханбогд сумын Жавхлант багийн иргэдийн нийтийн хуралд оролцож, осол зөрчлийг тайлбарлаж, асуултад хариулсан.
- 2023 оны 4-р сард хаягдлын далангийн шүүрэл зэрэг усны менежментийн асуудлаар ойлголттой болоход нь туслах зорилгоор нутгийн 24 малчныг Хаягдлын далангийн 1-р үүр, баяжуулах үйлдвэртэй биечлэн танилцуулсан.
- “Мөнх ногоон галба” ТББ, Ханбогд сумын Засаг дарга, орон нутгийн байгаль орчны байцаагч, нутгийн малчидтай авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хоёр долоо хоног тутам уулзалт хийж байна.
- БОАЖЯ, Усны газарт тогтмол мэдээлэл өгч байгаагаас БОАЖЯ-тай 2023 оны 9 дүгээр сард биечлэн уулзалт хийсэн.
- Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх (Зээлдүүлэгчдийн аудитор)-ийн 2018 оноос хойш 6 сар тутам гүйцэтгэж буй талбайн аудитаар энэ асуудлыг авч үзэж ирсэн. 2023 оны 1-р улирлаас эхлэн усны чанар, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хоёр долоо хоног тутам мэдээлэл өгч байна.
- “Оюу толгой”-н удирдлагын баг “Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд 2022, 2023 оны турш тогтмол мэдээлэл өгч байна.

2023 оны 9 сард Зээлдүүлэгчдийн хүсэлтээр Усны нарийвчилсан аудит (эндээс үзэж болно) хийгдсэний дараагаар шүүрлийн асуудлыг Зээлдүүлэгчид авч үзсэн.

“Оюу толгой” компани нь шүүрлийн асуудлыг шийдвэрлэхээр орон нутаг, Зээлдүүлэгчид, “Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэд хороод, Рио Тинто зэрэг бүх оролцогч талуудтай ил тод хамтран ажиллах, тогтмол мэдээлэл өгөх замаар нэгдсэн ойлголттой болох, хариу арга хэмжээг зөвшилцөх, үр дүнтэй хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч байна.

-ТӨГСӨВ-